



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2023/18/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261885 Цахим хаяг: Natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Эрдэнэзул
Утас: 261729 Цахим хаяг: erdenezulb@audit.gov.mn
Аудитор: М.Лхагвасүрэн
Утас: 261729 Цахим хаяг: Lkhagvasurenm@audit.gov.mn

Улаанбаатар хот
2023 он

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
Бусад асуудлын хэсэг	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Зөвлөмж	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	21
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С МАГНАЙСҮРЭН ТАНАА

0003 02.20 № 07/309
тантай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Барилга, хот байгуулалтын яамны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Барилга, хот байгуулалтын яамны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2021 оны 207 дугаар тогтоолоор "Цэвэр, бохир усны төлбөрийг төрөөс хариуцах"-аар шийдвэрлэсний дагуу Хот, суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл нь эзэмшигчээс ирүүлсэн цэвэр, бохир усны үйлчилгээний гүйцэтгэлийг хянан баталгаажуулж, тайлант онд Барилга, хот байгуулалтын яамны түр дансанд дамжуулан зарцуулах 26,431,228.9 мянган төгрөгийн санхүүжилт орсноос 25,273,308.2 мянган төгрөгийн санхүүжилтийг холбогдох байгууллагуудад шилжүүлж, 1,157,920.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх зээлийн санхүүжилтийн эх үүсвэрт жил бүр 5,000,000.0 мянган төгрөг тусгаж Төрийн орон сууцны корпорац ТӨХХК-ын Хөгжлийн банкнаас зээлсэн зээлийн үндсэн төлбөр төлөхөд зарцуулах зорилгоор Барилга, хот байгуулалтын яамтай 6 жилийн хугацаатай, хүүгүй дамжуулан зээлдүүлэх

Z:\Yawsan_Bichig\2023\0220\07\AC-8 Docx

0001050462

гэрээ байгуулан улмаар 2019-2022 онуудад нийт 20,000,000.0 мянган төгрөгийг төсвийн шууд захирагчийн төсөвт төлөвлөж, зарцуулсан байна.

Зээлийн хуваарь, тооцоо нийлсэн актыг тулгахад 1,800,000.0 мянган төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн, 18,200,000.0 мянган төгрөгийн эргэн төлөлтийн хугацаа болоогүй байна. Дамжуулан зээлдүүлэх гэрээнд зааснаар зээлдүүлэгч нь Барилга, хот байгуулалтын яам, зээлдэгч нь Төрийн орон сууцны корпорац боловч тус яамны тайланд тусгаагүй, зээлийн эргэн төлөлтийг Сангийн яамны төрийн сан банкны харилцах дансанд төлж байгаа нь эргэн төлөлтөд тавих хяналт сулрах, зээлийн эрсдэл үүсэж болзошгүй тул цаашид анхаарах шаардлагатай байна.

Бусад асуудлын хэсэг

Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 104 дүгээр тогтоолоор бүтэц орон тооны хязгаарыг 78 байхаар тогтоосон боловч батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарьт орон тоог 75-аар тусгасан байна.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



Z:\Audit\Bilgiz\2020\5\AG-8 Docx



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ДАНСНЫ КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	23,868,672.67	4,890,758,486.79
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	4,829,007,198.79
31100	Кассад байгаа бэлэн мөнгө	-	4,829,007,198.79
31120	Гадаад валют	-	4,829,007,198.79
33	АВЛАГА	-	11,786,000.00
33500	Бусад авлага	-	11,786,000.00
33510	Байгууллагаас авах авлага	-	11,786,000.00
34	УРЬДЧИЛГАА	1,687,667.67	28,356,743.00
34600	Урьдчилж гарсан зардал	1,687,667.67	28,356,743.00
35	БАРАА МАТЕРИАЛ	22,181,005.00	21,608,545.00
35400	Хангамжийн материал	22,181,005.00	21,608,545.00
35410	Бичиг хэргийн материал	1,376,425.00	4,301,825.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	1,480,000.00
35470	Бусад хангамжийн материал	20,804,580.00	15,826,720.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	333,563,803.83	293,970,289.28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	333,563,803.83	293,970,289.28
39200	Биет хөрөнгө	322,231,796.75	289,037,032.25
39203	Авто-тээврийн хэрэгсэл	417,279,798.00	250,324,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(215,863,661.13)	(73,940,263.09)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	435,644,182.97	493,647,952.97
39206	Хуримтлагдсан элэгдэл	(354,266,805.73)	(406,699,238.38)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	241,757,851.07	241,757,851.07
39208	Хуримтлагдсан элэгдэл	(209,650,128.11)	(220,940,309.84)
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,179,675.00	17,179,675.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(9,849,115.32)	(12,292,635.48)
39300	Биет бус хөрөнгө	11,332,007.08	4,933,257.03
39301	Программ хангамж	8,757,010.00	8,757,010.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,629,859.99)	(8,757,010.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	25,100,800.00	25,100,800.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(18,895,942.93)	(20,167,542.97)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	357,432,476.50	5,184,728,776.07
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,117,984.19	4,886,171,835.03
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,117,984.19	4,886,171,835.03
41300	Өглөг	2,117,984.19	4,886,171,835.03
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,117,984.19	47,823,636.24
41360	Бусад өглөг	-	4,838,348,198.79
41361	Байгууллагад төлөх өглөг	-	4,829,007,198.79
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	9,341,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	355,314,492.31	298,556,941.04
51	Засгийн газрын хувь оролцоо	355,314,492.31	298,556,941.04
51100	Засгийн газрын оруулсан капитал	324,390,884.93	324,390,884.93
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	324,390,884.93	324,390,884.93
51200	Хуримтлагдсан үр дүн	30,923,607.38	(25,833,943.89)
51210	Өмнөх үеийн үр дүн	614,976,112.91	31,200,194.89
51220	Тайлант үеийн үр дүн	(584,052,505.53)	(57,034,138.78)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	357,432,476.50	5,184,728,776.07

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	129,063,254,018.92	39,493,788,586.19
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	120,214,658,041.26	26,517,383,625.89
120	Нийтлэг татварын бус орлого	120,214,658,041.26	26,517,383,625.89
120009	Бусад орлого	120,132,227,339.00	26,459,379,855.89
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	82,430,702.26	58,003,770.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,848,595,977.66	12,976,404,960.30
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,918,499,600.00	8,541,515,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,918,499,600.00	8,541,515,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	930,096,377.66	4,434,889,060.30
131103	ЗГНХ,ЗДН Хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	579,059,160.00	150,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,282,517,560.30
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	351,037,217.66	2,371,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	124,647,306,524.45	34,575,817,724.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	124,647,306,524.45	34,575,817,724.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,928,145,979.76	7,722,453,764.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,978,263,033.00	2,001,462,154.20
210101	Үндсэн цалин	1,978,263,033.00	2,001,462,154.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	258,818,136.04	251,185,753.03
210201	Тэтгэврийн даатгал	180,690,216.82	172,108,920.21
210202	Тэтгэмжийн даатгал	20,101,830.65	20,248,108.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,842,903.92	15,996,886.36
210204	Ажилгүйдлийн даатгал	3,834,834.51	3,893,803.39
210205	Эрүүл мэндийн даатгал	38,348,350.14	38,938,034.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,371,500.00	12,657,900.00
210304	Байрны түрээс	10,371,500.00	12,657,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	82,780,032.66	42,904,535.45
210401	Бичиг хэрэг	18,629,110.00	8,016,222.21
210402	Тээвэр, шатахуун	16,254,700.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,549,582.66	7,532,077.79
210404	Ном, хэвлэл	14,614,500.00	18,911,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,732,140.00	8,445,235.45
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	985,800.00	790,500.00
210604	Урсгал засвар	985,800.00	790,500.00
2107	Томилолт, зочны зардал	7,631,900.00	4,256,060.00
210702	Дотоод албан томилолт	7,631,900.00	4,256,060.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	900,398,022.00	5,125,913,977.24
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	891,552,836.00	5,117,184,039.24
210803	Даатгалын үйлчилгээ	7,655,590.00	5,953,472.00

Барилга, хот байгуулалтын яам 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	488,596.00	561,448.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	79,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	602,000.00	2,135,718.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	688,897,556.06	258,287,884.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	598,101,802.00	160,690,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	90,795,754.06	97,597,284.55
212	ТАТААС	120,116,802,339.00	25,273,308,161.24
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	120,116,802,339.00	25,273,308,161.24
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	120,116,802,339.00	25,273,308,161.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	602,358,205.69	1,580,055,799.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	250,345,900.00	388,794,068.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	19,803,000.00	24,687,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	189,600,000.00	266,750,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	40,942,900.00	97,357,068.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	975,088.03	1,188,890,230.96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	975,088.03	1,188,890,230.96
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	351,037,217.66	2,371,500.30
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,371,500.30
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	351,037,217.66	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	4,415,947,494.47	4,942,969,861.22
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,000,000,000.00	5,000,000,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	5,000,000,000.00	5,000,000,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(584,052,505.53)	(57,034,138.78)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	129,524,611,266.66	43,829,752,383.69
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	120,132,227,339.00	30,853,347,423.39
120	Нийтлэг татварын бус орлого	120,132,227,339.00	30,853,347,423.39
120009	Бусад орлого	120,132,227,339.00	30,853,347,423.39
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,392,383,927.66	12,976,404,960.30
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,918,499,600.00	8,541,515,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,918,499,600.00	8,541,515,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,473,884,327.66	4,434,889,060.30
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	579,059,160.00	150,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	543,787,950.00	4,282,517,560.30
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	351,037,217.66	2,371,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА, ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	124,517,688,566.66	34,435,784,816.19

Барилга, хот байгуулалтын яам 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

21	УРСГАЛ ЗАРДАЛ	124,517,688,566.66	34,435,784,816.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,798,528,021.97	7,582,420,855.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,940,165,355.31	1,959,980,300.00
210101	Үндсэн цалин	1,204,138,857.25	1,201,357,432.45
210102	Нэмэгдэл	684,608,298.16	543,819,859.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	51,418,199.90	195,727,204.05
210104	Урамшуулал	-	19,075,803.59
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	261,923,400.00	244,997,700.00
210201	Тэтгэврийн даатгал	184,316,500.00	167,603,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	19,401,700.00	19,348,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,521,400.00	15,478,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,880,300.00	3,869,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	38,803,500.00	38,696,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,371,500.00	12,657,900.00
210304	Байрны түрээс	10,371,500.00	12,657,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	66,439,965.86	45,393,100.00
210401	Бичиг хэрэг	14,074,322.00	5,633,264.55
210402	Тээвэр, шатахуун	13,712,400.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,138,443.86	8,915,800.00
210404	Ном, хэвлэл	15,425,000.00	21,131,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,089,800.00	9,713,035.45
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	985,800.00	790,500.00
210604	Урсгал засвар	985,800.00	790,500.00
2107	Томилолт, зочны зардал	8,090,400.00	4,256,060.00
210702	Дотоод албан томилолт	8,090,400.00	4,256,060.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	914,941,708.80	5,152,739,095.69
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	903,518,622.80	5,143,608,157.69
210803	Даатгалын үйлчилгээ	7,655,590.00	5,953,472.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	488,596.00	561,448.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	79,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,179,900.00	2,536,718.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	595,609,892.00	161,606,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	595,609,892.00	161,606,200.00
212	ТАТААС	120,116,802,339.00	25,273,308,161.24
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	120,116,802,339.00	25,273,308,161.24
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	120,116,802,339.00	25,273,308,161.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	602,358,205.69	1,580,055,799.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	250,345,900.00	388,794,068.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	19,803,000.00	24,687,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	189,600,000.00	266,750,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	40,942,900.00	97,357,068.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	975,088.03	1,188,890,230.96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	975,088.03	1,188,890,230.96
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	351,037,217.66	2,371,500.30
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	351,037,217.66	2,371,500.30
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,006,922,700.00	9,393,967,567.50
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	9,296,100.00	

Барилга, хот байгуулалтын яам 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,296,100.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	9,296,100.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,296,100.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(9,296,100.00)	-
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(5,000,000,000.00)	(4,564,960,368.71)
14	Бусад эх үүсвэр	-	435,039,631.29
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	435,039,631.29
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	5,000,000,000.00	5,000,000,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	5,000,000,000.00	5,000,000,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-2,373,400.00	4,829,007,198.79
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,373,400.00	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	4,829,007,198.79

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	324,390,884.93	615,115,080.25	939,505,965.18
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	(138,967.34)	(138,967.34)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	324,390,884.93	614,976,112.91	939,366,997.84
Тайлант үеийн үр дүн	-	(584,052,505.53)	(584,052,505.53)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	324,390,884.93	30,923,607.38	355,314,492.31
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	276,587.51	276,587.51
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	324,390,884.93	31,200,194.89	355,591,079.82
Тайлант үеийн үр дүн	-	(57,034,138.78)	(57,034,138.78)
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	324,390,884.93	(25,833,943.89)	298,556,941.04

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,556,501,600.00	8,517,566,363.69	38,935,236.31	99.5
УРСГАЛ ЗАРДАЛ	3,556,501,600.00	3,517,566,363.69	38,935,236.31	98.9

Барилга, хот байгуулалтын яам 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,140,605,900.00	3,128,772,295.69	11,833,604.31	99.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,959,980,300.00	1,959,980,300.00	-	100.0
Үндсэн цалин	1,231,873,900.00	1,201,357,432.45	30,516,467.55	97.5
Нэмэгдэл	676,488,200.00	543,819,859.91	132,668,340.09	80.4
Унаа хоолны хөнгөлөлт	51,618,200.00	195,727,204.05	(144,109,004.05)	379.2
Урамшуулал	-	19,075,803.59	(19,075,803.59)	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	244,997,700.00	244,997,700.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	167,603,800.00	167,603,800.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	19,348,500.00	19,348,500.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	15,478,800.00	15,478,800.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	3,869,700.00	3,869,700.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	38,696,900.00	38,696,900.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,602,200.00	12,657,900.00	1,944,300.00	86.7
Байрны түрээс	14,602,200.00	12,657,900.00	1,944,300.00	86.7
Хангамж, бараа материалын зардал	24,262,100.00	24,262,100.00	-	100.0
Бичиг хэрэг	5,651,800.00	5,633,264.55	18,535.45	99.7
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,915,800.00	8,915,800.00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,694,500.00	9,713,035.45	(18,535.45)	100.2
Эд хогшил, урсгал засварын зардал	790,500.00	790,500.00	-	100.0
Урсгал засвар	790,500.00	790,500.00	-	100.0
Томилолт, зочны зардал	4,337,300.00	4,256,060.00	81,240.00	98.1
Дотоод албан томилолт	4,337,300.00	4,256,060.00	81,240.00	98.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	880,029,600.00	870,221,535.69	9,808,064.31	98.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	870,682,900.00	861,090,597.69	9,592,302.31	98.9
Даатгалын үйлчилгээ	6,146,000.00	5,953,472.00	192,528.00	96.9
Тээврийн хэрэгслийн татвар	571,600.00	561,448.00	10,152.00	98.2
Тээврийн хэрэгслийн оношилгоо	79,300.00	79,300.00	-	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,549,800.00	2,536,718.00	13,082.00	99.5
Бараа үйлчилгээний бусад зардал	11,606,200.00	11,606,200.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	11,606,200.00	11,606,200.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	415,895,700.00	388,794,068.00	27,101,632.00	93.5
Бусад урсгал шилжүүлэг	415,895,700.00	388,794,068.00	27,101,632.00	93.5
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	24,687,000.00	24,687,000.00	-	100.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	244,800,000.00	266,750,000.00	(21,950,000.00)	109.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	146,408,700.00	97,357,068.00	49,051,632.00	66.5

Барилга, хот байгуулалтын яам 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын тайлан

ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	5,000,000,000.00	5,000,000,000.00	-	100.0
Эргэж төлөгдөх зээл	5,000,000,000.00	5,000,000,000.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,556,501,600.00	8,517,566,363.69	38,935,236.31	99.5
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	8,556,501,600.00	8,517,566,363.69	38,935,236.31	99.5
Улсын төсвөөс санхүүжих	8,556,501,600.00	8,517,566,363.69	38,935,236.31	99.5
АЖИЛЛАГСДЫН ТОО	75	78	(3)	104.0
Удирдах ажилтан	11	17	(6)	154.5
Гүйцэтгэх ажилтан	64	56	8	87.5

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		4,434,889,060.30
УРСГАЛ ЗАРДАЛ		4,434,889,060.30
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		4,434,889,060.30
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		4,282,517,560.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		4,282,517,560.00
Бараа үйлчилгээний бусад зардал		150,000,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал		150,000,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,571,500.3
Засгийн газрын урсгал шилжүүлэг		2,571,500.3
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		2,571,500.3
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		4,432,517,560.30
Нэмэлт санхүүжилтийн орлого		4,432,517,560.30
ЗГНХ,ЗДН Хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		150,000,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,282,517,560.30

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 104 дүгээр тогтоолоор баталж, үйл ажиллагааны чиглэл, эрхэм зорилго, зорилтуудыг тодорхойлсон байна.

Барилга, хот байгуулалтын яамны эрхэм зорилго нь *“Барилга, хот байгуулалтын сайдын болон Засгийн газрын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, төрийн захиргааны удирдлага, зохицуулалт, хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх, үнэлэх, дүгнэх асуудлыг хамарсан Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн загварыг тодорхойлоход оршино.”* гэж тодорхойлсон байна.

Барилга, хот байгуулалтын яам нь эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн зорилтууд болох хот байгуулалт, газрын харилцаа, газар зохион байгуулалт, геодези, зураг зүй, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, орон сууц, инженерийн дэд бүтэц, нийтийн аж ахуйн салбарын нэгдсэн бодлого, төлөвлөлт, төсөл хөтөлбөрийг эрэмбэлэх, хувилбар боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, салбарын норм, нормативын баримт бичгийн тогтолцоог бүрдүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн салбарын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичиг, дүрэм, журмыг боловсронгуй болгох, бодлого, төлөвлөлт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хувилбар боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах зэрэг тэргүүлэх 7 зорилт, 26 гол зорилтуудыг дэвшүүлж ажилласан байна.

Барилга, хот байгуулалтын яам дор дурдсан тэргүүлэх чиглэлтэй байна:

1. Хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарыг хөгжүүлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх;
2. Орон сууц хөгжүүлэх, хэрэгжүүлэх бодлого боловсруулах;
3. Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх;
4. Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх;
5. Салбарын санхүү, эдийн засгийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх;
6. Салбарын хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих;
7. Төрийн захиргааны удирдлага, хүний нөөцийн манлайллыг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын тогтолцоог хэрэгжүүлэх, удирдлагаар хангах;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль ;
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Засгийн газрын 388 дугаар тогтоол “Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2022 оны 107 дугаар тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”;
- ЗГ-ын 2022 оны 192 дугаар тогтоол “Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Барилга, хот байгуулалтын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь Барилга, хот байгуулалтын яамны харьяа байгууллагуудын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын зарцуулалт зэрэгт дотоод аудит явуулах, эрсдэлийн удирдлагаар ханган дүгнэлт зөвлөмж боловсруулах, үр дүнг тайлагнах ажлыг зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор дотоод аудитын төлөвлөөг баталж төлөвлөгөөний дагуу 5 байгууллагад гүйцэтгэлийн аудит хийж нийт 32 зөвлөмж өгч зөвлөмжийн биелэлтийг 2023 оны 01 дүгээр улиралд багтаан харьяа газруудаас хүлээн авч танилцуулахаар төлөвлөн ажиллаж байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Барилга, хот байгуулалтын яам нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 63 дугаар тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлан мөрдөж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Барилга, хот байгуулалтын яамны 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,802.3 сая төгрөгөөр буюу 1,343.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		4,829,007.2	4,829,007.2
Авлага		11,786.0	11,786.0

Барилга, хот байгуулалтын яам 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Урьдчилгаа	1,687.7	28,356.7	26,669.0
Бараа материал	22,181.0	21,608.5	(572.5)
Үндсэн хөрөнгө	333,563.8	293,970.3	(39,593.5)
Нийт хөрөнгө	357,432.5	5,184,728.7	4,827,296.2
Өр төлбөр	2,118.0	4,886,171.8	4,884,053.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	355,314.5	298,556.9	(56,757.6)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	357,432.5	5,184,728.7	4,827,296.2

Өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 4,829,007.2 мянган төгрөг болсон нь Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН3244/3245 төсөл”-ийн хүрээнд Барилга, хот байгуулалтын яам, Ludwig Pfeiffer Hoch und Tietbau GmbH болон Emit Group, Ericole Marelli Impainti Technologuci S.l.r түншлэл хооронд “Дархан хотын цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, насос станц болон 12 сарын зүгшрүүлэлтийн дэмжлэг үзүүлэх” А1/158 дугаартай гэрээ байгуулсан боловч гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсны улмаас гүйцэтгэлийн баталгааг цуцлан 1,401.9 мянган ам.долларыг тус яамны төрийн сан дахь валютын дансанд төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдлийн 11,786.0 мянган төгрөг нь "Улаанбаатар принт" ХХК-аас авах авлага 2,445.0 мянган төгрөг, мөн худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүдийн урамшуулал болох 9,341.0 мянган төгрөгийг Сангийн яамнаас авах авлагаар тусгаснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 293,970.3 мянган төгрөг болж 39,593.5 мянган төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А-1/2458 дугаар албан бичгийн дагуу Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байсан 58,003.8 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн орлого авсан, тайлант онд 97,597.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл тооцсоноос шалтгаалжээ.


Өр төлбөр дансны үлдэгдэл 4,886,171.8 мянган төгрөг болж 4,884,053.8 мянган төгрөгөөр өссөн нь “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл”-ийн гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсны улмаас гүйцэтгэлийн баталгааг цуцлан, 1,401.9 мянган ам доллар буюу 4,829,007.2 мянган төгрөгийг тус яамны төрийн сан дахь валютын дансанд төвлөрүүлснийг өглөгөөр бүртгэсэн, татвар, нийгмийн даатгалын өглөг 47,823.6 мянган төгрөг, худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүдийн урамшуулал 9,341.0 мянган төгрөгийг Сангийн яамнаас авах авлага, гишүүдэд өгөх өглөгөөр тус тус тайланд тусгаснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 298,556.9 мянган төгрөг болж 56,757.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Барилга, хот байгуулалтын яамны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 89,569,465.4 мянган төгрөгөөр буюу 69.4 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт 623,016.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, бусад орлого 93,672,847.4 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна. Бусад орлого буурсан нь өнгөрсөн онд Засгийн газрын 2021 оны 207 дугаар тогтоолын дагуу айл өрх, аж ахуй нэгжид цэвэр бохир усны дэмжлэг олгохтой холбогдуулан 120,116,802.3 мянган төгрөгийг санхүүжүүлсэн бол тайлант онд 26,427,131.9 мянган төгрөгийг санхүүжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Нийт зардлыг өмнөх онтой харьцуулахад 90,071,488.8 мянган төгрөгөөр буюу 72.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас санхүүжилтийн зардал 94,843,494.1 мянган төгрөгөөр буурч



бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 4,250,511.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь "Ногоон нуур-1008" төслийн газар чөлөөлөлтийн үйл ажиллагааны санхүүжилтын дүнгээр өссөнтэй холботой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 9,406,124.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж улсын төсвөөс санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төслийн саналаас 849,623.2 мянган төгрөгөөр бууруулж, 8,556,501.6 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 470,193.2 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 58,773.9 мянга, байр ашиглалттай холбоотой зардал 3,607.8 мянга, хангамж, бараа материалын зардал 45,525.2 мянга, эд хогшил, урсгал засварын зардал 195,3 мянга, томилолт, зочны зардал 31,481.3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 141,137.9 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 8,393.8 мянга, урсгал шилжүүлэг 90,314.8 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 8,556,501.6 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр төлөвлөснөөс 14,985.7 мянган төгрөгөөр дутуу буюу 8,541,515.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 8,517,566.4 мянган төгрөгийг зарцуулж, 23,949.5 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нийт баталсан төсвийн 58.4 хувь буюу 5,000,000.0 мянган төгрөг нь Барилга, хот байгуулалтын яам болон Төрийн орон сууцны корпорац ТӨХХК-тай дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулан төсвийн шууд захирагчийн төсөвт төлөвлөж, батлуулан олгосон эргэн төлөлтийн зээл байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 8,517,566.4 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой зардлыг 1,944.3 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 81.2 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийг 9,808.1 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийг 27,101.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээ 38,935.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71509	Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бодлого	8,556,501.60	8,517,566.40	38,935.2	99.5
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,671,716.70	2,660,454.10	11,262.6	99.6
80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	336,575.60	336,004.60	571.0	99.8

Барилга, хот байгуулалтын яам 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

80226	Байр ашиглалтын үйлчилгээ	132,313.60	132,313.60	-	100.0
80704	Ахмад дайчин, алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж	244,800.00	244,800.00	-	100.0
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	171,095.70	143,994.10	27,101.6	84.2
83117	Орон сууцжуулах	5,000,000.00	5,000,000.00	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас Ногоон нуур 1008 айлын орон сууц төслийн газар чөлөөлөлтийн төлбөрт 4,282,517.6 мянга, Засгийн газрын нөөц сангаас Засгийн газрын 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн "Хөрөнгө гаргах тухай" 316 дугаар тогтоолоор Азийн архитекторуудын форум 21 олон улсын арга хэмжээнд 150,000.0 мянган төгрөг, худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүдийн урамшуулал болох 2,371.5 мянган төгрөг нийт 4,434,889.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 4,432,517.6 мянган төгрөгийг зарцуулж, 2,371.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Барилга, хот байгуулалтын яамны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, томилолтын зардалд мөнгөн урьдчилгааны тайлан гаргуулж, хэвшихтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэзул, аудитор М.Лхагвасүрэн нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Барилга, хот байгуулалтын яамны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03/277 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 124,647,306.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 1,869,709.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн тоон үзүүлэлт өмнөх оноос материаллаг зөрүүтэй байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 39,575,817.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 593,637.3 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага дараах арга хэмжээ авч ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд ТӨБЗГ-ын 2022 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 360, 326 дугаар тогтоолуудын дагуу Хьюндай Сонат 7 маркийн 2 автомашин, Тоёота Ланд круйзер 200 маркийн 1 автомашиныг "Засгийн газрын авто бааз" ТӨААТҮГ-т балансаас баланст шилжүүлснээр холбогдон гарах 13,712.4 мянган төгрөгийн шатахуун, 6,480.0 мянган төгрөгийн зогсоолын түрээс, 1,702.1 мянган төгрөгийн даатгалын зардал хэмнэсэн байна. Мөн сургалт семинарыг цахимаар зохион байгуулснаар

1,380.0 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардлыг 3,834.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт орлогын 23 мэдээлэл, зарлагын 105 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд нийт 290,510.9 мянган төгрөгийн 6 асуудлыг илрүүлж асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн ба жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 18,061.5 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулсан байна. Биелэлт хангалтгүй 272,449.4 мянган төгрөгийн 1 алдаа зөрчлийг тайлант оны буруу илэрхийлэлд оруулсан. Нийцлийн аудитаар өгсөн 1,600.0 мянган төгрөгийн 1 алдааг бүрэн зассан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 61,631.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд давтан гаргахгүй байх 1 зөвлөмж, 3,529.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	3,529.1	1	3,529.1	100
Зөвлөмж	1	61,631.2	1	61,631.2	100
Нийт дүн	2	65,160.3	2	65,160.3	100

Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлагын бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас хэрэгжүүлж буй бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журмын хэрэгжилт, нийцлийн асуудлыг дараагийн аудитаар авч үзэхээр шийдвэрлэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12,376.1 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 2 алдаа¹ илэрснийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв. Үүнд:

- Тайлант онд 8,120.0 мянган төгрөгийн 2700 ширхэг барилгын тэргүүний ажилтны үнэмлэх болон жуух, жуух бичгийн хавтас зэргийг ямар нэгэн хяналтгүйгээр шууд зардалд бүртгэсэн;
- Томилолтын зардалд мөнгөн урьдчилгааны тайлан гаргуулж, хэвшээгүй, тайлант онд нийт 4,256.1 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг ажилтнуудын харилцах дансанд шилжүүлсэн боловч мөнгөн урьдчилгааны тайлан гаргаагүй, томилолтын гүйцэтгэл, анхан шатны баримтын бүрдэл зэрэгт хяналт хэрэгжүүлээгүй.

Аудитаар нийт 81,034.6 мянган төгрөгийн зөрчилд² 3 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 81,034.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 593,637.3 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Зөвлөмж

1. Урьдчилж гарсан зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хамтран ажиллах гэрээний дагуу ажил гүйцэтгүүлсэн нэр бүхий 5 байгууллагын 24,995.0 мянган төгрөгийн гүйцэтгэлийн тайлан гараагүй байхад зардлаар тайлагнасан нь Сангийн сайдын 2006 оны 388 тоот “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” тоот тушаалын 4 дүгээр зүйлийн 4.28 дах заалт “Бэлтгэн нийлүүлэгч болон хувь хүмүүст төлсөн урьдчилгаа, ба урьдчилан гарсан зардлыг: Дт. Урьдчилж төлсөн төлбөрүүд Кт. Мөнгөн хөрөнгө / Дансны өглөг” гэж бүртгэнэ, Хамтран ажиллах гэрээний 4.1.1 Гэрээний хэрэгжилтийн явцын, дундын жилийн эцсийн тайлан мэдээллийг тогтмол авч, гүйцэтгэлийг хянах гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урьдчилж гарсан зардлаар тайлагнаж гүйцэтгэлийн тайланг үндэслэн зардлаар хүлээн зөвшөөрөх зөвлөмж өгөх,

2. Өглөгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд татвар, нийгмийн даатгалд 47,823.6 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Татвар, нийгмийн даатгалын өр төлбөрийг хуулийн хугацаанд нь төлж хэвших, төсвийг зохистой удирдаж өр, авлагагүй ажиллах,

3. Хэмнэлтийн тухай хуультай холбоотой асуудал

Илрүүлэлт:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Спортын арга хэмжээнд 8,216.0 мянган төгрөг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4. "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15.2.3. "... болон холбогдох бусад зардлыг хэмнэх", Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн "Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 388 тоот тогтоолын 5.4." .. биеийн тамирын уралдаан тэмцээн ... зэрэг зардлыг тус тус 100 хувь хэмнэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хэмнэлтийн тухай хуулийн 12.1.4. хуулиар зөвшөөрөгдөөгүй бусад зардал, Монгол Улсын Засгийн газрын 388 дугаар тогтоолын 5.4. биеийн тамирын уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх зэрэг заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант онд 8,120.0 мянган төгрөгийн 2700 ширхэг барилгын тэргүүний ажилтны үнэмлэх болон жуух жуух бичгийн хавтас зэргийг ямар нэгэн хяналтгүйгээр шууд зардалд бүртгэсэн	1	8,120.0			1	8,120.0					1	8,120.0
Томилолтын зардалд мөнгөн урьдчилгааны тайлан гаргуулж, хэвшээгүй байна. Тайлант онд нийт 4,256.1 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг ажилтнуудын харилцах дансанд шилжүүлсэн боловч мөнгөн урьдчилгааны тайлан гаргаагүй, томилолтын гүйцэтгэл, анхан шатны баримтын бүрдэл зэрэгт хяналт хэрэгжүүлээгүй	1	4,256.1			1	4,256.1					1	4,256.1
Дүн	0	12,376.1	-	-	1	12,376.1	-	-	-	-	1	12,376.1

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд татвар, нийгмийн даатгалд 47,823.6 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.	1	47,823.6					1	47,823.6
Хамтран ажиллах гэрээ байгуулан ажил гүйцэтгүүлсэн нийт 5 байгууллагын 24,995.0 мянган төгрөгийн гүйцэтгэлийн тайлан гараагүй байхад зардлаар тайлагнасан.	1	24,995.0					1	24,995.0
Спортын арга хэмжээнд 8,216.0 мянган төгрөг зарцуулсан	1	8,216.0					1	8,216.0
Дүн	2	81,034.6					2	81,034.6